



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/259

Булган сум

### Ажлын хэсэг байгуулан хэлэлцүүлэг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II дугаар хуралдааны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн ерөнхий боловсролын сургуулийн захирал, биеийн тамирын багш нарын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Батчимэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Б.Одхүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,  
эрх зүйн хэлтсийн дарга)

Ж.Ганболд (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)

Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)

Т.Баярбат (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн  
газрын дарга)

Ё.Хулан (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спортын бодлого,  
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

Я.Нямсүрэн (Боловсрол, шинжлэх ухааны газрын  
Биеийн тамирын боловсрол хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Б.Бат-Эрдэнэ (аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн Боловсролын бодлого,  
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)

2. Хэлэлцүүлэг зохион байгуулах удирдамжийг 1 дүгээр, үйл ажиллагааны хөтөлбөрийг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Хэлэлцүүлэг зохион байгуулахад шаардагдах 1,932,000 (нэг сая гурван зуун наян мянга) төгрөгийг “Шинэ Багш” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дүгээр сарын 17-ны өдрийн А/259 дугаар  
захирамжийн 1 дүгээр хавсралт



**БУЛГАН АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
БИЕИЙН ТАМИРЫН БАГШ НАРЫН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ**

**Нийтлэг үндэслэл:** Булган аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Шинэ Багш” дэд хөтөлбөрийн хүрээнд боловсролын салбарын удирдлага, багш нарын мэргэжлийн ур чадвар, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, тэдний хөдөлмөрийн үнэлэмж, арга зүйн хөгжлийг дэмжих, тэргүүн туршлага, ур чадвараа түгээн дэлгэрүүлэх боломжийг бүрдүүлэх.

**Зорилго:** Булган аймгийн ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нарын мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжиж, харилцан туршлага солилцох боломжийг олгох, хүний эрх, ёс зүйн хэм хэмжээ, хууль, эрх зүйн мэдлэг олгох, уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах

**Хугацаа, удирдлага зохион байгуулалт:** 2023 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр 09:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын -ын 107 тоот

**Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл:**

- Биеийн тамирын багш нарын уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Биеийн тамирын хичээлийн талаархи мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх
- Боловсрол, шинжлэх ухааны газар, Биеийн тамир спортын газрын мэдээлэл, танилцуулга хийх
- Хүүхдийн эрх, багшийн ёс зүй, хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт зохион байгуулах

**Хамрах хүрээ:**

Булган аймгийн нийт Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалтын үйлдвэрлэлийн төвийн биеийн тамирын багш, арга зүйч

Холбоо барих: БШУГ, Биеийн тамирын боловсрол хариуцсан мэргэжилтэн Я.Нямсүрэн, Утас: 99969245



Аймгийн Засаг даргын 2023 оны  
01 дүгээр сарын 17-ны өдрийн А.259 дугаар  
захирамжийн 2 дугаар хавсралт

**БУЛГАН АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
БИЕЙН ТАМИРЫН БАГШ НАРЫН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР**

Цаг	Үйл ажиллагаа	Үргэлжлэх хугацаа (минут)	Хариуцах эзэн
1	2	3	4
09:00-09:10	Нээлт	10	Аймгийн Засаг дарга
09:10-09:15	Төрийн дуулал	5	Б.Ариун-Эрдэнэ
09:15-09:25	БТСГ-ын танилцуулга, мэдээлэл	10	БТСГ-ын дарга Х.Батхишиг
09:25-09:35	БШУГ-ын танилцуулга, мэдээлэл	10	БШУГ-ын дарга Ж.Ганболд
09:35-10:00	Боловсролын салбар дахь Биеийн тамирын боловсрол олгох чиглэлээр баримталж буй бодлого	20	БШУГ-ын БТБХ мэргэжилтэн Я.Нямсүрэн
10:00-10:25	ЕБС-ийн сургуулийн сурагчдыг секц, дугуйланд хамруулах, зал талбай, хэрэглэл материал, багш дасгалжуулагч нарын урамшуулал, ажиллах орчин нөхцлийн тухай	20	БШУГ-ын дарга Ж.Ганболд
10:25-10:40	Уралдаан тэмцээнд оролцоход тулгарч буй асуудал	20	БТСГ-ын дарга Х.Батхишиг
10:40-11:10	Асуулт, хариулт	30	Нийт оролцогчид
11:10-11:40	Цайны завсарлага	20	АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн Б.Бат-Эрдэнэ
11:40-12:00	Боловсролын салбар дахь хууль эрх зүй, үүрэг хариуцлага, Багшийн ёс зүй, цаашид анхаарах асуудал	20	АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн Ж.Оюунгэрэл
12:00-12:20	Сургуулийн насны хүүхдийн сэтгэл зүйг таних, харилцах ур чадвар	20	ГБХЗХГ-ын Сэтгэл зүйч Б.Оюун-Эрдэнэ
12:20-13:10	Өдрийн хоол	45	Зохион байгуулах ажлын хэсэг
13:10-13:30	Хүүхэд хамгааллын анхаарал асуудал, цаашид баримтлах бодлого, чиглэл	20	ГБХЗХГ-ын дарга Т.Баярбат
13:30-15:00	Асуулт хариулт, хэлэлцүүлэг	90	Зохион байгуулах ажлын хэсэг
15:00-15:10	Хаалт	10	Зохион байгуулах ажлын хэсэг
15:10-15:30	Өсвөрийн шигшээ багийн үзүүлэн тоглолт	20	БТСГ-ын дарга Х.Батхишиг

04 дүгээр сарын 17-ны өдрийн А/250 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



**БУЛГАН АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
БИЕИЙН ТАМИРЫН БАГШ НАРЫН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГИЙН ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үнэ /төгрөг/	
				Нэг бүр	Нийт
1	2	3	4	5	6
1	Бага үдийн цай	1ш	84	5,000	420,000
2	Хоол	1ш	84	18,000	1,532,000
НИЙТ ДҮН					1,932,000